



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баримт бичгийн үйлчлэх хугацаа: 2021-2024 он /4 жил/

Төлөвлөгөөг баталсан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

/Г.БАТЗАМ /

Огноо: 2021 онысарынөдөр

Төлөвлөгөөг боловсруулсан:

Төсвийн Шууд захирагч

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

/Б.ОТГОНЧИМЭГ/

Огноо: 2021 онысарынөдөр

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

Нийтлэг үндэслэл

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /цаашид "ГХБХБГ" гэх/-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хуулиуд, Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого, шийдвэр, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсруулсан болно.

Үндэслэл

Стратеги төлөвлөгөөг дараах баримт бичгүүдийг үндэслэн боловсруулав. Үүнд:

- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Газрын тухай хууль
- Геодези, зураг зүйн тухай хууль
- Газрын кадастр ба кадастрын зураглалын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай
- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай
- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай
- Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"
- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "АЛСЫН ХАРАА-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 26 дугаар тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолоор баталсан "Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		44
үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	16 /Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Барилгын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж.
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	28 /Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Барилгын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Монгол Улсын хилийн тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын бүртгэлийн багц хууль, Татварын багц хууль/
Ерөнхий чиг үүрэг: ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Геодези, зураг зүй	Жижиг, дунд, том масштабын /газар дээрх болон доорх биетийн/ байр зүйн тоон зургаар үйлчлэх	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал
	Аймгийн газар зүйн нэрийг тодотгон тогтоох, газар зүйн нэрийг баяжуулах ажлыг удирдах	
	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайлан хүлээн авах, дүгнэх, мэдээллийн санг хөтлөх	
ҮЧҮ-2: Суурь мониторинг	судалгаа, Доройтолд орсон газруудыг тодорхойлох, газар хамгаалах, нөхөн сэргээх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал
	Суурь судалгаа, геологи, хүрээлэн буй орчны мэдээллийн санг эрхлэх, хэрэглээнд гаргах	
	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалангийн газрын нөхөн сэргээлт хийх эрх авсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх, тайланг хүлээн авах, мэдээллийн сан хөтлөх	
ҮЧҮ-3: Газар зохион байгуулалт	Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал
	Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн сан байгуулах, хөтлөх	
	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх авсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх, тайланг хүлээн авах, мэдээллийн сан хөтлөх	
	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалт, хилийн цэсийн асуудлыг эрхлэх	
	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийг газар ашиглалтын зориулалт тус бүрээр газрын улсын бүртгэлд	

ҮЧҮ-4: Кадастр	бүрэн хамруулж, төрийн нэрийн өмнөөс газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг нь баталгаажуулах, санхүү, бүртгэлд тусгах, хөрөнгийн баталгаа болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал
	Газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлийг улсын хэмжээнд хөтлөх, газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хяналт тавих, Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системийг эрхлэх	
	Газрын биржийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хяналт тавих	
	Газар, үл хөдлөх, хөрөнгийн зах зээлийг оновчтой тодорхойлж, Газрын үнэ, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	
	Газрын зөрчил маргааныг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	
	Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн хаягийг кадастрын мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулах, хаягийн мэдээллийн нэгдсэн системийг эрхлэх	
ҮЧҮ-5: Орон зайн мэдээлэл, технологи	Байгууллагын сүлжээ, техник, программ хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
	Орон зайн мэдээлэл, үйлчилгээний шинэлэг, баталгаатай, чанартай, бэлэн байдлыг хангах, олон нийтэд түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангах	
ҮЧҮ-6: Төрийн архив	Салбарын төрийн архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах, хэрэглэгчдэд үйлчлэх	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
	Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, бусад байгууллага хэлтсүүдтэй хамтран ажиллах	
	Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх	
ҮЧҮ-7: Хот төлөвлөлт	Хот байгуулалтын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг хангах, тэдгээрийг боловсронгуй болгох судалгаа, саналыг боловсруулах	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Аймаг, хотын Ерөнхий архитектор
	Хот байгуулалт, хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн болон норм, нормативын баримт бичгийг боловсруулахад санал өгөх, мөрдүүлэх, сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих	
ҮЧҮ-8: Хот байгуулалтын кадастр	Аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийг байгуулах, ажиллуулах, хот, суурин газарт хот байгуулалтын кадастрыг эрхлэх ажлыг зохион байгуулах	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
	Хот байгуулалтын кадастрын үйл ажиллагаа, мэдээллийн сантай холбоотой эрх зүйн болон норм, нормативын баримт бичгийг боловсруулахад санал өгөх, сурталчлах ажлыг зохион байгуулах.	
	Хот байгуулалтын кадастрын чиглэлээр боловсон хүчин, хүний нөөцийг сургаж бэлтгэх, орон нутаг дахь тухайн асуудлыг хариуцсан нэгжийн дарга, мэргэжилтнүүд, аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторуудыг чадавхижуулах сургалтуудад хамруулах	
ҮЧҮ-9 Барилга, барилгын материал үйлдвэрлэл	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүдийн судалгаа мэдээллийг хийж, мэдээллийн сан үүсгэх, мэргэжлийн зүгээс зөвөлгөө дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
	“Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх лабораторийн үйл ажиллагааг явуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, итгэмжлэл авна.	
	Улсын болон орон нутаг хөгжил сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажилд үе шатны техник хяналтыг хэрэгжүүлэх.	
	Барилгын ажлын явцад осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт сурталчилгааг зохион байгуулах, энэ талын зааварчилгааг тогтмол өгч байх ажлыг аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах.	
	Барилга байгууламжид ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, байнгын ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах.	
	Барилга байгууламжийн хувийн хэргийн хөтлөлтийн ажлыг зохион байгуулах, хөтлөлтөд хяналтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	
	Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй барилга байгууламжийн судалгаа мэдээллийг тогтмол шинэчлэн гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээ мэдээллээр хангах.	
	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам	

ҮЧҮ-10 Инженерийн дэд бүтэц		сүлжээний хүчин чадлын урьдчилсан судалгаа мэдээлэл хийх, санал боловсруулан холбогдох арга хэмжээ авч ажиллах.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
		Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажилд судалгаа хийж санал боловсруулан, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	
		Орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаанд оролцож хяналтыг хэрэгжүүлэх, судалгаа мэдээллийн сан үүсгэх.	
		Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын асуудалд судалгаа хийж, хамтран ажиллах.	
		Аймгийн төвийн сумын барилга, тохижилт, инженерийн дэд бүтцийн мэдээллийг маягтын дагуу бүрдүүлж, байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүрэн оруулж дуусгах.	
		Дулаанаар хангагч ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа мэдээлэл авах, нэгтгэх, хамтран ажиллах.	
		Сумдын шаардлагатай хэсгүүдэд СӨХ байгуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	
ҮЧҮ-9: Төрийн удирдлага, ажиллагаа	захиргаа, хамтын	Салбарт хэрэгжиж байгаа ажил, үйлчилгээг үр шим хүртэгсдийн хамт хэрэглээгээр шалган хүлээн авах, баталгаажуулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй заавар, журам, дүрэм, технологийн шийдлийн хэрэгжилтэд хяналт тавих	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал,
		Хүний нөөцийн бүртгэлийг хөтлөх, чадавхийг дээшлүүлэх, дотоод ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт, ажлын байранд тавигдах дадлага, туршлагын стандарт шаардлагыг тогтоож, сургалтын хэрэгцээг тодорхойлох, дадлагажуулах	
		Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, агентлагийн болон бүтцийн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт, баримтжуулалтыг нэгтгэж гаргах, хэрэгжилтийн чанарт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	
		Гэрээ, бусад шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангуулах, Газрын дарга, бүтэц зохион байгуулалтын нэгжийн дарга, мэргэжилтнүүдэд хууль зүйн болон мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	
		Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах, хэрэглэгчдэд үйлчлэх	
ҮЧҮ-10: Санхүү, эдийн засаг		Санхүү, нягтлан бодох бүртгэл, төсвийн удирдлага болон гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

АЛСЫН ХАРАА

“УХААЛАГ ТӨЛӨВЛӨЛТӨНД СУУРИЛСАН ЦАХИМ ГАЗРЫН ХАРИЛЦАА, ХОТ БАЙГУУЛАЛТ”

ЭРХЭМ ЗОРИЛГО

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР ДҮНГ ЭРХЭМЛЭЖ, ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЗАМААР ХҮН АМЫН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ, АЯ ТУХТАЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ОРШИНО.

Орчны шинжилгээ

Дотоод орчин	
<u>Давуу тал</u> - Олон жил бүтэц, зохион байгуулалтын хувьд тогтвортой ажиллаж ирсэн. - Байгууллагын өөрийн гэсэн соёлыг хэвшүүлж чадсан. - Албан хаагчдын ихэнх хувь нь байгууллагадаа тогтвортой ажилласан. - Тодорхой хэмжээний төсөв, хөрөнгө оруулалт батлагддаг. - Аймгийн хэмжээнд томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсэний үр дүнд орон зайн мэдээллийн нөөцийг бүрдүүлж чадсан.	<u>Сул тал</u> - Албан хаагчдын хэрэгцээнд суурилсан сургалт хангалтгүй - Төсөв хөрөнгийн дутагдалтай байдал - Өдөр тутмын бичиг цаасны ажил, мэргэжлийн нарийн технологийн ажил холилдсон. - Хэлтэс хоорондын үйл ажиллагааны уялдаа сул.
Гадаад орчин	
<u>Боломж</u> - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой зорилтууд тусгагдаж батлагдсан. - Мэдээллийн болон технологийн нөөцийн хувьд бэхжсэн.	<u>Эрсдэл</u> - Багц хуулийн төслүүд батлагдах эсэх нь тодорхойгүй. - Орон нутагт улс төрөөс хамаарсан томилгоо хийгддэг. - Орон нутагт мэргэжилтнүүдийн тогтвор суурьшил. - Орон зайн мэдээллийн сангийн шинэчлэлт удаашралтай.

Стратегийн зорилго

Газрын харилцааны салбарт мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх замаар газрын харилцаа, барилга хот байгуулалттай холбоотой төрийн үйлчилгээг цахимжуулж, үйл ажиллагааны шуурхай, мэргэжлийн, ил тод байдлыг хангахад оршино.

Байгууллагын бүтцийн уялдаа

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажлын хамрах хүрээ нь аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамарсан тогтвортой хөгжил, бүтээн байгуулалтын суурь инженерийн ажлууд болох газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, кадастр, орон зайн мэдээллийн дэд бүтэц, хот байгуулалт, түүний кадастрыг эрхлэх асуудлууд байх ба эдгээр асуудлаар яам, бусад агентлаг, орон нутаг, байгууллага, иргэдтэй холбогдоно.

Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратегид тусган хэрэгжүүлнэ.

----oOo----

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: ГАЗАР ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР</i>							
<i>Үндсэн чиг үүргийн нэр: ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ</i>							
1.1.Газар зүйн нэрийг тодотгох ажлыг зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэнэ.							
Зорилт-1. Аймгийн хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ. (ЗГҮАХХАХТ-3.7.2.6)	арга хэмжээ-1 Газар зүйн нэрийн тодруулалт (2021-2024)	Аймгийн газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулж, хэрэглээнд гаргах	Сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийгдээгүй.	3 сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж, мэдээллийн сан байгуулна.	Орон нутгийн төсөв, үйл ажиллагаа	2022 онд сумдын ОНХС-ийн 9,8 сая төгрөгөөр “Эс Эм Стар Геоид” ХХК-иар зөвхөн хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Дээрх ажлын үргэлжлэл болох Шивээговь сумын газар зүйн нэрийг тодруулах, хувийн хэрэг үүсгэх, мэдээллийн сан бий болгох ажлыг 2023 онд орон нутгийн төсвийн 12.5 сая төгрөгөөр мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компани болох “Климакс реферэнс” ХХК нь гүйцэтгэн ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт болон сумын газар зүйн салбар зөвлөлд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүлээлгэн өгсөн. Мөн Шивээговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор газар зүйн хээрийн тодруулалт суурин судалгаагаар шинээр үүссэн 17 нэршил болон 1:100 000 байр зүйн зурагт байгаа Улсын Их хурлаар батлагдаагүй 2 нэршилийг батлуулан ажилласан. Сүмбэр, Баянтал сумын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалтын үргэлжлэл ажил болох хувийн хэрэгжүүлэх, мэдээллийн сан бий болгох, зурагжуулах ажлын төсөв болох 55.7 сая төгрөгийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулан батлуулсан.Үүнд: • Баянтал сум-12.7 сая төгрөг • Сүмбэр сум-43 сая төгрөг Баянтал сумын газар зүйн нэрийн тодруулалтын үргэлжлэл ажил болох мэдээллийн сан үүсгэх, хувийн хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компани болох Климакс реферэнс ХХК-иар хийж гүйцэтгүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Баянтал сумын Засаг даргын Тамгын газартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулаад байна.	70
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: ГАЗАР ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР</i>							
<i>Үндсэн чиг үүргийн нэр: СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГ</i>							

2.1.Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хийнэ.							
Зорилт-1. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоо бүрдүүлэн хяналт тавина. (ЗГҮАХХАХТ-3.7.4.6)	арга хэмжээ-1 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг цахимаар хүлээн авч баталгаажуулах (2021-2024)	Баталгаажуулсан тайлангийн тоо, Газрын төлөв байдал, чанарын /захиалгат, төлөвлөгөөт/ хянан баталгааны ажлын нэгдсэн тайлан	Аймгийн хэмжээнд 8 орчим иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрынхаа төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийлгэсэн	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайланг хийнэ	Үйл ажиллагаа	Аймгийн хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 43 нэгж талбарт захиалгат хянан баталгаа хийлгэх мэдэгдэх хуудас хүлээлгэн өгснөөс 29 нэгж талбарын хянан баталгааны тайлан дүгнэлтийг хянаж баталгаажуулсан ба 2024 оны байдлаар өссөн дүнгээр 329 нэгж талбарын хянан баталгааг цахимаар ирүүлснийг баталгаажуулаад байна. Хүрсэн түвшин: 329 нэгж талбар захилгат хянан баталгаа хийлгүүлсэн.	100
Ерөнхий чиг үүргийн нэр: ГАЗАР ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР							
Үндсэн чиг үүргийн нэр: КАДАСТР							
3.1..Хаягжилтын ажлыг үргэлжлүүлэн, мэдээллийн санг хөтөлнө.							
Зорилт 1. Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. (ЗГҮАХХАХТ-3.7.2.5)	Арга хэмжээ 1. Хаягийн мэдээллийн системийг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх (2021-2024)	Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем Хаягийн мэдээллийн сангийн зам заагч болон веб систем Гар утасны аппликэйшн	-	Хаягийн мэдээллийн санд суурилсан зам заагч систем болон хаягийн мэдээллийн системийн олон нийтэд зориулсан веб болон гар утасны аппликэйшныг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Орон нутгийн төсөв	2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд хаягийн мэдээллийн санд суурилсан гар утасны аппликэйшны хөгжүүлэлт хийгдээгүй болно. Иргэд, олон нийт www.eqazar.gov.mn цахим сайтын хаягийн мэдээллийн систем цэснээс улсын хэмжээний хаягийг харах боломжийг бүрдүүлсэн.	100
3.2.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн үйл ажиллагааг эрхэлнэ.							
Зорилт 1. Цахим үйл ажиллагаатай Газрын	арга хэмжээ-1 Цахим үйл ажиллагаатай газрын бирж	Газрын сан бүрдүүлэх	2018 онд Газрын биржийн системийг хэрэглээнд	Цахим үйл ажиллагаатай Газрын биржийг газрын асуудал	Орон нутгийн төсөв	Газрын биржийн үйл ажиллагаа 2015 оноос эхлэн үйл ажиллагаанд нэвтрүүлж ашиглаж хэвшсэн бөгөөд дуудлага худалдааг 100% цахимаар зохион байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолоор улсын хэмжээнд эзэмшүүлэх,	30

биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан газрын биржийн үйл ажиллагааны тодорхой хувиар газар хөгжүүлэх санг бүрдүүлнэ. (ЗГҮАХХАХТ-3.7.3.1)	байгуулах (2022-2023)		нэвтрүүлсэн.	эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, Газрын биржийн үйл ажиллагааны орлогын тодорхой хувиар газрын сан бүрдүүлсэн байна.		ашиглуулах газрын байршил хэмжээ, зориулалтыг баталсан. Уг тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 7 байршлын 7,1 га талбайд дуудлага худалдаа зохион байгуулах ба Баянтал сумын Засаг даргын 2024 оны 04 сарын 26-ны өдрийн А/57 тоот захирамжийн дагуу 1 байршилд дуудлага худалдаа явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн газрын биржийн цахим системээр дамжуулан 37 нэгж талбарын зах зээлийн үнийн мэдээ бүртгэсэн байна. Хүрсэн түвшин: Зах зээлийн үнийн мэдээ 37 бүртгэсэн.	
Зорилт-2. Хиймэл оюун ухаан болон блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ. (ЗГҮАХХАХТ-3.7.3.2)	арга хэмжээ-1 Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн систем байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх (2022-2024)	Олон Улсын жишигт нийцсэн байх	Газрын татвар, төлбөрийн зорилготой масс үнэлгээний системийг байгуулсан.	Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Орон нутгийн төсөв	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн системийг 2020 оноос нэвтрүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. 2024 онд газрын төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээг үндэслэн нийт 11397 нэгж талбарт татвар, төлбөрийн ногдуулалтыг үүсгэж татварын системд илгээж ажилласан. Үүнд: - 1983 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт - 9414 нэгж талбарт газрын татварын ногдуулалт үүсгэсэн. Үр дүн: Татварын хэлтэс газрын татвар, төлбөрийг үүсгэсэн нэхэмжлэхийн дагуу хураах ажлыг хэрэгжүүлж байна. 2024 оны 05 дугаар сарын 05-ны байдлаар 85,253,996 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлсэн байна. Хүрсэн түвшин: 11397 нэгж талбарт газрын татвар, төлбөрийн ногдуулалтыг хийсэн.	100
	арга хэмжээ-2 Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээс авах үйлчилгээг иргэдэд хүргээмжтэй хүргэх (2021-2023)	Хэрэглэгчийн тоо	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн	www.egazar.gov.mn-ээс үйлчилгээ авсан хэрэглэгчийн хандалтыг 30 хувиар нэмэгдүүлсэн байна.	Үйл ажиллагаа	2024 оны 05 сарын 17-ны өдрийн байдлаар Газрын кадастрын цахим системд нийт 169 өргөдөл бүртгэгдсэн бөгөөд үүнээс 150 өргөдөл хүсэлт www.egazar.gov.mn цахим сайтын тусламжтайгаар цахим хүсэлт илгээсэн байна. Цахим өргөдөл хүсэлт нийт өргөдлийн 88,8 хувийг эзэлж байна.	100
Ерөнхий чиг үүргийн нэр: ГАЗАР ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР							

Үндсэн чиг үүргийн нэр: ХОТ БАЙГУУЛАЛТ							
4.1 Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол, шинэчлэл хийнэ.							
Зорилт1: Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ.	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд санал боловсруулах, судалгаа хийх, холбогдох байгууллагуудт ай хамтран ажиллах	Төлөвлөлт өөрчлөлт хийгдсэн байршлын тоо	-	Төлөвлөлт өөрчлөлт хийгдсэн байршлын тоо-3	АОНХС	2023-2024 онд Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын гүйцэтгэгчээр “Сонголт дизайн” ХХК шалгарч, хагас жилийн байдлаар төлөвлөгөөг 100 хувь гүйцэтгэн хүлээлгэн өгөх шатандаа байна. Байгууллагын зүгээс ажлын хэсэгт ажиллах, зураг төсөл хянаж батлах ажлуудад хамтран ажилласан. Хүрсэн түвшин: Төлөвлөлт өөрчлөлт хийгдсэн байршлын тоо - 2	100
Зорилт2: Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.	Дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхэд мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд оролцон ажиллах.	Дахин төлөвлөлт хийгдэх байршлын тоо	-	Дахин төлөвлөлт хийгдэх байршлын тоо-2	АОНХС, Хувийн хэвшил	Дахин төлөвлөлтийн ажлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг “Жаргалант хийц” ХХК-тай 18,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэж, магадлал хийлгэх шатандаа байна. 2023 онд дахин төлөвлөлтийн ажлын төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж дуусахад цахилгааны техникийн нөхцөл олгох асуудал шийдвэрлэгдэхгүй хугацаа алдсан боловч БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр салбараас техникийн нөхцлийг олгохоор зөвшилцөлд хүрч, техникийн нөхцөл олгогдсон. Зураг төслийг магадлалаар хянуулах шатандаа байна. Байгууллагын зүгээс төслийн судалгааны ажил, зураг төслийн төлөвлөлтийн зургийг хянах ажилд хамтран ажилласан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийн явц 90 хувьтай Хүрсэн түвшин: Дахин төлөвлөлт хийгдэх байршлын тоо-2	70
Ерөнхий чиг үүргийн нэр: ГАЗАР ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР							
Үндсэн чиг үүргийн нэр: ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН ЦАХИМ СИСТЕМ:							
5.1 Хот суурин газрыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцыг хөгжүүлж, ард иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцлийг сайжруулна.							
Зорилт:1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлын урьдчилсан судалгаа мэдээлэл хийх,	Судалгаа мэдээллийн гүйцэтгэлийн хувь	Ус хангамж ариутгамжын шугам сүлжээний мэдээллийн санг бүрдүүлэх ажил -90% буюу 23350м Ариутгах татуурганы шугамын мэдээллийн санг бүрдүүлэх ажил	Судалгаа мэдээллийн гүйцэтгэлийн хувь-100	Үйл ажиллагаа	Хот байгуулалтын кадастрын цахим системд дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөн баяжил хийн ажиллаж байна. 2024 онд шинээр ашиглалтад оруулсан цахилгаан хангамжийн 1, барилга угсралтын 1 ажлын гүйцэтгэлийн зургийг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэснийг хүлээн авч баяжуулалт хийсэн. Аймгийн хэмжээнд нийт 240 барилга байгууламж, 10 дурсгалын хөшөө, баримал, 1816м дугуйн зам, 7025м явган хүний зам, 298561м2 ногоон байгууламжийн талбай, 5 усан оргилуур, 6 оршуулгын газар, 25617.37м ус хангамжийн шугам, 9546м дулаан хангамжийн шугам, 10398.73м ариутгах татуургын шугамын	

	санал боловсруулан холбогдох арга хэмжээ авч ажиллах.		-83% буюу 10398м Дулаан хамгамжын шугам сүлжээний мэдээллийн санг бүрдүүлэх ажил-90% буюу 9546м, Хот тохижилт, ногоон байгууламжын мэдээллийн санг бүрдүүлэх ажил-30%			мэдээллийн бүрдүүлэлттэй байна. Хүрсэн түвшин: Дэд бүтцийн шугам сүлжээний мэдээллийн хувь-90%	90
Зорилт:2 Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажилд судалгаа хийж санал боловсруулан, холбогдох байгууллагуудт ай хамтран ажиллах.	Зураг төсөл боловсруулах гүйцэтгэлийн хувь Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн хувь	-	Зураг төсөл боловсруулах гүйцэтгэлийн хувь-100 Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн хувь-100	АОНХС	1.Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын хүрээнд захиалгаар "Найрамдал хотхон"-ны ус зайлуулах системийн ажлын зургийг 2019 онд "Гидро дизайн инноваци"ХХК -р хийлгэсэн боловч 2023-2024 онд Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын гүйцэтгэгч "Сонголт дизайн"ХХК-иас зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай саналыг гаргаад байна. 2. Хагас жилийн байдлаар "Найрамдал хотхон"-ы авто замын ус зайлуулах зураг төслийг 19,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "Гидро дизайн инноваци"ХХК -р гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулаад байна. 3. Аймгийн Онцгой байдлын газарт 2024.02.24-ны 01/49 албан бичгээр Сүмбэр сумын хэмжээнд байгаа авто зам дагуух ус зайлуулах хоолойн байршлын судалгааг гарган хүргүүлсэн. Судалгаанд 6 байршил хамрагдсан байна. Хүрсэн түвшин: Авто замын ус зайлуулах зураг төсөл боловсруулсан тоо-1, гүйцэтгэлийн хувь-100% Боловсруулах шатандаа-1, гүйцэтгэлийн хувь-30%	100
Зорилт:3 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	Орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаанд оролцож хяналтын хэрэгжүүлэх, судалгаа мэдээллийн сан үүсгэх.	Зураг төсөл боловсруулах гүйцэтгэлийн хувь Ашиглалтад орох орон сууцны барилгад хамрагдах өрхийн тоо	-	Зураг төсөл боловсруулах гүйцэтгэлийн хувь-100 Ашиглалтад орох орон сууцны барилгад хамрагдах өрхийн тоо-240 айл	Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	- Сүмбэр сум 3 дугаар багт 315 айлын орон сууц бариулахаар орон нутгаас газрын асуудлыг бодлогоор дэмжиж 1,8 га газрыг шийдвэрлэсэн. -Мөн орон сууцны гадна цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд "Шинээр баригдах хотхоны гадна цахилгаан хангамж 6кв ЦДАШ, 2Х630 кВа хаалттай дэд өртөө"-ний ажлыг орон нутгийн төсвийн 240,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Осо-констракшн" ХХК гүйцэтгэж байна. 2024 оны 5 дугаар сарын байдлаар дэд өртөөний засал, тоноглолын ажил дуусч байна. Цахилгаан хангамжийн ажилд 100% захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. -Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийтийн орон сууцны төсөл сонгон шалгаруулалтын нээлтийн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2024.03.07-ны өдөр зохион байгуулж , сонгон шалгаруулалтаар "Өргөө засал"ХХК 144 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан байна. -Мөн Сүмбэр сумын 3-р багт "Осо констракшн"ХХК 36 айлын орон	100

						сууцны барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 2024.07.01-ний дотор байнгын ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай. Хүрсэн түвшин: Зураг төсөл боловсруулах гүйцэтгэлийн хувь – 100% Шинээр баригдах орон сууц -1, ашиглалтад орох орон сууц -1, Айл өрхийн тоо -180	
Зорилт:4 Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын бодлогоор дэмжинэ.	Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын асуудалд судалгаа хийж, хамтран ажиллах.	Орон сууц, хаус хороолол барих санал ирүүлсэн иргэдийн тоо	-	Орон сууц, хаус хороолол барих санал ирүүлсэн иргэдийн тоо - 2	Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийтийн орон сууцны төсөл сонгон шалгаруулалтын нээлтийн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2024.03.07-ны өдөр зохион байгуулж, сонгон шалгаруулалтаар “Өргөө засал”ХХК 144 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан байна. Мөн Сүмбэр сумын 3 байршлын 8 хэсэгт 1000 айлын орон сууц, 2 байршилд 80 айлын хаус хорооллын төсөл сонгон шалгаруулалтыг 2024.05.21-ны өдөр хүртэл дахин зарлаад байна. Байгууллагын зүгээс ажлын хэсэгт ажиллах, газрын асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллаж байна. Хүрсэн түвшин: Орон сууц, хаус хороолол барих санал ирүүлсэн ААН-н тоо – 3 Аймаг, орон нутагт орон сууц хаус хороолол барих санал санаачлагыг газрын бодлогоор дэмжин 2018, 2019, 2021, 2022, 2023 онуудад 7 төрийн байгууллагад 65672м2 газрыг орон сууц, хаусын зориулалтаар аймаг, сумын Засаг даргын захирамжаар олголт хийн ажилласан байна. Мөн Сүмбэр сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд 1 төрийн байгууллагад 3 байршилд орон сууцны зориулалтаар 97538 м2 газрыг олгохоор Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 06 дугаар тогтоолоор батласан. Үүнд: ➤ Оюутаны гудамж 2-225 тоотын урд талд 32057м2 газрыг ➤ Найрамдал хотхон 26 тоотын урд талд 33702м2 газрыг Гомбосүрэн ноёны өргөн чөлөө тоотын зүүн хойд талд 31779м2 газрыг тус тус батлуулан ажилласан.	100
Зорилт:5 Хот байгуулалтын кадастрын цахим системийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Аймгийн төвийн сумын барилга, тохижилт, инженерийн дэд бүтцийн мэдээллийг маягтын дагуу бүрдүүлж, байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын	Аймгийн төвийн сумын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний мэдээллийн гүйцэтгэлийн хувь	Мэдээллийн санд орсон барилга байгууламж -127 Ус хангамж шугам сүлжээний мэдээллийн санг бүрдүүлэх ажил -90% буюу 23350м Ариутгах татуурганы шугамын мэдээллийн санг бүрдүүлэх ажил -83% буюу 10398м Дулаан хангамжийн	Аймгийн төвийн сумын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний мэдээллийн гүйцэтгэлийн хувь -100	Улс төсөв, АОНХС, Төсөл хөтөлбөр	-Хот байгуулалтын кадастрын urban.gov.mn цахим системд барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох болон дэд бүтцийн мэдээллийн сан хөтлөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. -2024 оны 05 дугаар сарын байдлаар urban.gov.mn цахим системээр иргэн, хуулийн этгээдээс барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой хүсэлтийг хүлээн авч 3 аж ахуйн нэгж байгууллагын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох үйлчилгээг шийдвэрлэж ажиллаж байна. -Хот байгуулалтын кадастрын мэдээллийн цахим системд аймгийн хэмжээнд нийт 240 барилга байгууламж, 10 дурсгалын хөшөө, баримал, 1816м дугуйн зам, 7025м явган хүний зам, 298561м2 ногоон байгууламжийн талбай, 5 усан оргилуур, 6 оршуулгын газар, 25617.37м ус хангамжийн шугам, 9546м дулаан хангамжийн шугам,	100

	кадастрын мэдээллийн санд бүрэн оруулж дуусгах.		шугам сүлжээний мэдээллийн санг бүрдүүлэх ажил-90% буюу 9546м, Хот тохижилт, ногоон байгууламжын мэдээллийн санг бүрдүүлэх ажил- 30%			10398.73м ариутгах татуургын шугамын мэдээлэлийн бүрдүүлэлттэй байна. Хүрсэн түвшин: Дэд бүтцийн шугам сүлжээний мэдээллийн хувь-90%	
Ерөнхий чиг үүргийн нэр: ГАЗАР ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР							
Үндсэн чиг үүргийн нэр: БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ:							
6.1 Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэх.							
Зорилт:1 Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүдийн судалгаа мэдээллийг хийж, мэдээллийн сан үүсгэх, мэргэжлийн зүгээс зөвөлгөө дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүдийн судалгаа мэдээллийг хийж, мэдээллийн сан үүсгэх, мэргэжлийн зүгээс зөвөлгөө дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.	Мэдээлэл судалгааны гүйцэтгэлийн хувь Үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн тоо	Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо -2	Мэдээлэл судалгааны гүйцэтгэлийн хувь -100 Үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн тоо -3	Үйл ажиллагаа	-Барилгын материал үйлдвэрлэлийн судалгааг 2024.05.02-ны өдөр аймгийн хэмжээнд хийсэн. Үүнд бетон зуурмагийн 1, вакум цонхны 1, бетон эдлэлийн 2 үйлдвэрлэл тус тус үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс хагас жилийн байдлаар барилгын материал үйлдвэрлэлийн 3 аж ахуйн нэгж материал үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдэрлэн ажиллаж байна. Үүнд: 1."Илчит сансар"ХХК - ф1000-н кольцо 32ш, ф1500-н кольцо 32ш, ф700-н кольцо 24ш, лотки 10ш, ф1000 ташуу таг 10ш, ф1500-н ташуу таг 10ш, 2."Алтан булаг уул"ХХК - 200 м3 бетон зуурмаг. 3."Осо-Констракшн"ХХК - Вакум цонх 200м2, вакум хаалга 50м2 зэрэг бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн байна. Хүрсэн түвшин: Судалгааны гүйцэтгэлийн хувь-100 Барилгын материал үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн тоо-3	100
Зорилт:2 Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэх, өргөжүүлэн зохион байгуулан ажиллах.	"Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх лабораторийн үйл ажиллагааг явуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, итгэмжлэл авна.	Шинжилгээний төрөл, шинээр нэмэгдүүлсэн лабораторийн тоног төхөөрөмжийн тоо, итгэмжлэл авах ажлын гүйцэтгэлийн хувь	Шинжилгээний төрөл – 8, шинээр нэмэгдүүлсэн лабораторийн тоног төхөөрөмжийн тоо - 4	Шинжилгээний төрөл – 9, Тоног төхөөрөмж – 2, итгэмжлэл авах ажлын хувь – 100%	Үйл ажиллагаа	-Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг 2018 оноос эрхлэн ажиллаж байна. Хагас жилийн байдлаар Шивээговь сумын авто замын ажил, Баянтал сумын 154-р байрны дээврийн ажил зэрэгт 2 төрлөөр лабораторийн шинжилгээг БХТ-тэй хамтран хийсэн байна. 3. Барилгын материалын лабораторийн итгэмжлэл авахад үндсэн бичиг баримт болох "Чанарын гарын авлага"-ыг боловсруулах ажил 85%-тай хийгдэж байна. Хүрсэн түвшин: Лабораторийн шинжилгээ -2 Шинжилгээний төрөл – 9 Тоног төхөөрөмжийн нэр төрөл-46 Итгэмжлэл авах гүйцэтгэлийн хувь-85%	100

Зорилт:3 Барилгын ажлын үе шатны хяналтыг холбогдох хууль, норм дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.	Улсын болон орон нутаг хөгжил сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажилд үе шатны хяналтыг хэрэгжүүлэх.	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	Хөрөнгө оруулалтын ажлын тоо -21	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн хувь-100	Үйл ажиллагаа	-Улсын болон орон нутаг, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй нийт 29,7 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 45 ажилд захиалагчийн хяналтын гэрээг байгуулан ажиллаж байна.Үүнээс хагас жилийн байдлаар нийт 13 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаж, Хүрсэн түвшин: Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн хувь -100	100
Ерөнхий чиг үүргийн нэр: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ							
Үндсэн чиг үүргийн нэр: ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ХАМТЫН АЖИЛЛАГАА							
7.1. Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна. (ЗГҮАХ)							
Зорилт 1. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина. Үүнд: - Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын	Газрын тухай хуулийн ажлын хэсэгт ажиллах, хуулийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж хамтран ажиллах (2021-2024)	Хуулийн төслийн саналаа ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Байгууллагын мэргэжилтэн нараас хуулийн төсөлд саналыг авч нэгтгэн боловсруулсан	Хуулийн төсөлд өгөх саналаа дээд шатны байгууллага болон УИХ-д өргөн барьсан байна.	Үйл ажиллагаа, урсгал зардал	Газрын багц хуулийн төслийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдрүүдийн хооронд хэлэлцүүлэгийг зохион байгуулан ажилласан. Тус хэлэлцүүлэгт нийт 489 иргэд танхимаар хамрагдаж хуулийн төслүүдтэй танилцаж санал хүсэлтээ өгч ажилласанаас гадна цахимаар 31 иргэн санал өгсөн байна. Хэлэлцүүлэгийн тайланг УИХ-ын Тамгын газар болон ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.	100
	Газрын төлбөрийн тухай хуулийн ажлын хэсэгт ажиллах, хуулийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж хамтран ажиллах (2021-2023)	Хуулийн төслийн саналаа ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна..	Байгууллагын мэргэжилтэн нараас хуулийн төсөлд саналыг авч нэгтгэн боловсруулсан	Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна.	Үйл ажиллагаа, урсгал зардал	Газрын багц хуулийн төслийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдрүүдийн хооронд хэлэлцүүлэгийг зохион байгуулан ажилласан. Тус хэлэлцүүлэгт нийт 489 иргэд танхимаар хамрагдаж хуулийн төслүүдтэй танилцаж санал хүсэлтээ өгч ажилласанаас гадна цахимаар 31 иргэн санал өгсөн байна. Хэлэлцүүлэгийн тайланг УИХ-ын Тамгын газар болон ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.	100
	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх	Хуулийн төслийн	Байгууллагын мэргэжилтэн нараас хуулийн төсөлд	Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан	Үйл ажиллагаа, урсгал зардал	Газрын багц хуулийн төслийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдрүүдийн хооронд хэлэлцүүлэгийг зохион байгуулан	100

төсөл (ЗГҮАХХАХ Т-3.7.1.1)	тухай хуулийн ажлын хэсэгт ажиллах, хуулийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж хамтран ажиллах (2021)	саналаа ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	саналыг авч нэгтгэн боловсруулсан	байна.		ажилласан. Тус хэлэлцүүлэгт нийт 489 иргэд танхимаар хамрагдаж хуулийн төслүүдтэй танилцаж санал хүсэлтээ өгч ажилласанаас гадна цахимаар 31 иргэн санал өгсөн байна. Хэлэлцүүлэгийн тайланг УИХ-ын Тамгын газар болон ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.	
8.2. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ. (ЗГҮАХ)							
Зорилт 1. Хяналт- шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын тогтолцооны чадавхийг бэхжүүлэх, үр нөлөөг дээшлүүлнэ	Сумын газрын даамал нарын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх (2021-2024)	2 жилд 1 удаа хяналт шинжилгээг хийсэн байна.	2 жилд 1 удаа хяналт шинжилгээ хийдэг.	Хяналт шинжилгээний ажил тогтмолжиж, үр нөлөө сайжирсан байна.	Томилолтын зардал	2024 оны хагас жилийн байдлаар хяналт шинжилгээний ажил хийгдээгүй байна.	ҮБ
Зорилт 2. Байгууллагын ил тод байдлыг хангах, үйл ажиллагааны давхардал, хийдлийг арилгах, үйлчилгээний стандартыг сахих, авилгаас ангид байх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхайн байх нөхцөл боломжийг бүрдүүлэх (2021-2024)	Байгууллагын цахим хуудасны шинэчлэлтийн н шуурхай байдал	Цахим хуудсан 2019 онд шинэчлэгдсэн.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.	Үйл ажиллагаа	Байгууллагын govsumber.gazar.gov.mn сайт нь 11 үндсэн цэс болон 106 дэд цэсэнд нийт 1886 мэдээ мэдээллүүдийг тухай бүр нь байршуулан иргэд, олон нийтэд мэдээлэлсэн. 2024 оны хагас жилийн байдлаар байгууллагын сайтанд нийт 126 зар, мэдээ, мэдээлэл, тайлан байршуулсан байна.Үүнд - Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан тушаал шийдвэр 5 - Сар бүр хийсэн ажлуудын тайлан 4 удаа - Газрын харилцааны чиглэлээрх мэдээлэл 56 - Барилга, хот байгуулалттай холбогдолтой 18 - Өргөдөл, гомдол шийдвэрлэлт 1 - Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүүтэй холбоотой 42 мэдээ, мэдээллийг тус тус байршуулсан байна. Үүнээс гадна байгууллагын пэйж хуудсаар мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулан ажиллаж байна. Мөн мэдээллийг тогтмол график үзүүлэлт, тоон мэдээлэл, зурган мэдээлэл, статистик үзүүлэлтээр гарган оруулж хэвшсэн. Мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулахдаа иргэд томруулж харах, хэвлэж авах болон татаж авах боломжтойгоор байршуулж хэвшсэн. Үүний үр дүнд иргэд төрийн үйлчилгээг авахад илүү хялбар, шат дамжлага бага, явдал чирэгдэл багатайгаар хүртэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод цахим	100

						хэлбэрээр байршуулах, нийтлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллаж байна.	
9.1 Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно. (ЗГҮАХ)							
Зорилт 1. Хүний нөөцийн нэгдсэн цахим сан (төрийн албан хаагчийн хувийн хэрэг, шилжилт хөдөлгөөн, сэлгэн ажиллуулах, шагнал урамшуулал, албан тушаалын өөрчлөлт, цол, зэрэг, дэв олгох гэх мэт үзүүлэлттэй байх) бүрдүүлнэ.	Салбарын хүний нөөцийн мэдээллийг тасралтгүй, тогтмол шинэчлэх (2021-2024)	Хүний нөөцийн бүртгэл судалгааны чанартай байдал	2020 онд хүний нөөцийн дотоодын програм боловсруулсан.	Хүний нөөцийн судалгааг 7 хоног бүр шинэчлэх боломжтой болсон байна.	Үйл ажиллагаа	2024 оны байдлаар байгууллагын батлагдсан 21 орон тооноос ажиллаж байгаа 17 хүн байна. Үүнээс албан тушаалын байдлаар ТЗ-14, ТҮ-3 албан хаагч ажиллаж байна. ХНУМС-д 17 албан хаагч бүртгэлтэй ба мэдээллийг тухай бүр шинжилж ажиллаж байна.	100
Зорилт 2. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх чиглэлээр үе шаттай ажил зохион байгуулах замаар байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах (2021-2024)	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" 2020-2025-ийг баталсан.	Хөтөлбөрийг 90 хувьтай хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаа	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр газрын даргаар батлуулсан. 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	100
Зорилт 3. "Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр"-ийн дагуу ажилтнуудыг сургалтад хамруулна.	Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах (2021-2024)	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.	Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаа	-Албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор байгууллага дотооддоо төлөвлөгөө гарган сургалтыг зохион байгуулж хэвшсэн. - Байгууллагын дотоод сургалтыг 1 дүгээр улиралд нийт 13 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулласан. - Ажил мэргэжлийн чиглэлээр чадавхижуулах зорилгоор болон бусад чиглэлүүдээр дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд: 1. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн 4 дэхь өдөр зохион байгуулсан 19 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 190 албан хаагч; Үүний үр дүнд албан хаагчдын мэдлэг чадвар сайжирч, иргэн, хуулийн этгээдэд мэдээ мэдээлэлийг үнэн зөв бодитой түргэн	100

						шуурхай хүргэх, багаар ажиллах чадвар сайжрах зэрэг олон давуу талууд бий болсон байна.	
10.1 Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ. (ЗГҮАХ)							
Зорилт 1. Санхүү, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангана.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх (2021-2024)	Санхүүгийн хяналт шалгалтын дүн	Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод тайлагнаж ажилладаг.	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.	Үйл ажиллагаа	www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь нийт 57 ш мэдээллийг бүрэн байршуулан ажилласан.Үүнд: • Сар бүр цэсэнд 16 ш • Хагас жил бүр цэсэнд 0 ш • Жил бүр цэсэнд 3 ш • Тухай бүр цэсэнд 38 ш мэдээллийг тус тус байршуулж мэдээлсэн. • Аудитын дүгнэлтийн биелэлтийг аудитын “Баталгаат тооцоолол” ХХК-д биелэлтийн 05 дугаар сарын 15-ны өдөр 02/156 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. Үүний үр дүнд санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй ил тод тогтмол байршсан.	100
Нийт хувь							94.1%

-----000-----

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

Б.ОТГОНЧИМЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Т.УРАНТОГОС

